



ХЭНТИЙ АЙМАГ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 12

Чингис хот

Салбар комисс байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.1, 2013 оны 86 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 5.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хэнтий аймагт 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулагдах төрийн албаны мэргэшлийн шалгалт авах, шалгалттай холбоотой иргэдээс гарсан санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар комиссын дарга:	Ж.Гантулга	-Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ч.Болормаа	-Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	С.Бат-Эрдэнэ	-Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
	Г.Болд	-Салбар зөвлөлийн гишүүн, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
	Г.Лхагвахатан	-Салбар зөвлөлийн гишүүн, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

2. Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцсэн иргэдийн нэрсийн жагсаалтыг нэгтгэн салбар комиссын дүгнэлт, холбогдох материалыг хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР